



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/401

Зуунмод

Аймаг, сумын баяр наадмын тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 10.4.6, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” тогтоолын 1, 3, мөн 2021 оны 118 дугаар тогтоолоор батлагдсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, 2021 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” тогтоолын 3, 4, 2021 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын 1, Улсын Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр “Халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” албан даалгаврын 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын орон нутаг дахь түвшин, эрсдэлийн нөхцөл (эрсдэлийн үнэлгээ маш өндөр) байдалтай холбогдуулан аймгийн Онцгой комиссын саналыг харгалзан аймаг, сумын баяр наадмыг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, зохион байгуулахыг цуцалсугай.

2. Баяр наадмыг зохион байгуулах арга хэмжээний зардлаас хэмнэгдсэн төсвийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд зарцуулахыг аймаг, сумын Онцгой комисс, сумын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Орон нутгийн хэмжээнд уул, овооны тахилга, наадам, тэмдэглэлт ой, хурдан морины (сунгаа, үсэргээ) уралдаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг), Төв аймаг дахь Цагдаагийн газар (Б.Ганзориг) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

2121011101